

БАТЛАВ.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар баталгаажсан дээр дурдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, төрөөс иргэнийхээ өмнө хариуцсан үүргийг биелүүлэх зорилгоор сүүлийн жилүүдэд олон хууль тогтоомж батлагдан гарч, хүчин төгөлдөр үйлчилж байна. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль нь хуульчдын үйл ажиллагааны хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд нэгдсэн шаардлага, стандарт, хариуцлагын тогтолцоог бий болгох, уг арга замаар тэдгээрийн мэдлэг, ур чадвар, ёс зүйг нэмэгдүүлэн хуульчдын нэр хүнд, олон нийтийн итгэл, хүндлэлийг олж авах, хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын зохистой бүтцийг бий болгох зорилгоор батлагдсан.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар тухайн үед зохицуулалт хангалтгүй байсан хууль зүйн дэд бүтэц, хуульчдын хүрээ, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх чухал алхам болсон хэдий ч хууль хүчин төгөлдөр үйлчилсэн хугацаанд уг хуулийг шинэчлэн найруулах доор дурдсан хэрэгцээ, шаардлага байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль үйлчилж эхэлснээр хуучин үйлчилж байсан Өмгөөллийн тухай 2002 оны хууль хүчингүй болгосон. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэгч өмгөөлөгчдийн үйл ажиллагаанд хамааралтай бүхий л шийдвэрийг мэргэжлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй чиг үүргийн хувьд байнгын ашиг сонирхлын зөрчилтэй байдаг шүүгч, прокурорын давуу оролцоотойгоор шийдвэрлэдэг эрх зүйн орчныг бий болгосон, хуульчийн шалгалтад тэнцсэн хэн боловч Улсын Дээд шүүхэд бүртгүүлснээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх болсон нь өмгөөллийн үйл ажиллагааны бие даасан, өмгөөлөгчийн хараат бус

байдлыг эрсдэлд оруулаад зогсохгүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Прокурорын тухай, Шүүхийн захиргааны тухай хуулиудад прокурорын болон шүүгчийн ёс зүй, сахилгын хариуцлагын асуудлаар Прокурорын ёс зүйн зөвлөл болон Шүүхийн ёс зүйн хороо үйл ажиллагаа явуулахаар тус тус заасан. Ингэснээр Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо нь зөвхөн өмгөөлөгч нарт холбогдох маргааныг хянан шийдвэрлэж байгаа буюу тус хороо нь зөвхөн өмгөөлөгч нарт хамаарах байдал бий болсон нь хуулийн гол үзэл санааны нэг болох хуульчийн нэгдсэн хариуцлагын тогтолцоог үгүйсгэсэн, түүнийг практикт хэрэгжих боломжгүй болгосон.

Түүнчлэн Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүдийг батламжлах эрх бүхий Их Хурал хуралдах хугацаа нь Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаанаас зөрүүтэй, хуульд заасан “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэх нэр томъёоны талаархи зохицуулалтыг Үндсэн хуульд нийцээгүй үндэслэлээр хүчингүй болгосноор хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэж юу болох талаар тодорхойгүй байдал үүссэн, хуульчийн шалгалтыг жилд нэг удаа зохион байгуулахаар тусгасан нь оновчгүй бөгөөд зардал, ачааллыг зохиомлоор өсгөх үндэслэл болсон, хуулийн тодорхой бус зохицуулалтын улмаас хууль зүйн боловсролын чанарыг дээшлүүлэх зорилго бүхий хуулийн гол үзэл санааны нэг хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх зохицуулалт өдийг хүртэл хэрэгжээгүй, хуульд туссан шүүгчийн мэргэжлийн ёс зүйн асуудлыг Хуульчдын холбооны дэргэдэх байгууллагаар шийдвэрлэхээр зохицуулсан нь хуульд заасан шүүгчийн хараат бус, халдашгүй байдлын зарчмуудтай зөрчилдөх, хараат бус байдлын баталгааг хөндсөн, шүүгчдийн эрх зүйн байдлыг дордуулсан зэрэг үндэслэл байна.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр тус хуулийн нэлээдгүй зохицуулалт нь зорилгодоо бүрээгүй буюу зорилгодоо хүрэхийн тулд хуулийн зохицуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна гэж дүгнэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөл нь хуульчдын нийтлэг эрх, ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн байх бөгөөд энэ нь хуульчид тавигдах шаардлага, хуульчийн шалгалт, хууль зүйн сургуулийн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх замаар эрх зүйн боловсролын агуулгад тавих стандартыг тодорхойлоход чиглэгдсэн зохицуулалтыг агуулсан байна.

Хуулийн төсөлд уг хуулийн зорилго нь хуульчийн эрх зүйн байдал, түүний мэргэжлийн үйл ажиллагаа, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой байхаар төсөлд тусгана.

Нийтлэг үндэслэлийг тодорхойлсон нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим зэргийг тодорхойлно.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалт, түүнийг зохион байгуулах, хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох ажил, хуульчийн шалгалтад орох тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх болон хуульчийн шалгалтад оруулахаас татгалзсан шийдвэрт гомдол гаргах зэрэг хуульчийн шалгалттай холбогдсон харилцааг тусгана. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн ерөнхий зарчмыг хэвээр хадгалах боловч шалгалтад орох хүсэлт гаргах журам, мэргэжлийн дадлагад тооцох ажил, албан тушаал зэргийн талаархи зохицуулалтыг илүү боловсронгуй болгож, хуульчийн мэргэшлийн сургалтыг шинээр нэмж, уг сургалтад хамрагдсан байх нь хуульчийн шалгалтад орох нөхцөл байхаар тусгана.

Гуравдугаар бүлэгт хуульчийн зөвшөөрөл, түүнийг олгох журам, хуульч мэргэжлийн нэрийг хэрэглэх эрх, хуульчийн зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлэх, хуульчийн зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл, хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгох талаархи харилцааг зохицуулна.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл, хуульчийн эрх, үүрэг, тангараг, түүнд хориглох зүйл, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрмийн талаархи зохицуулалтыг тусгана. Түүнчлэн энэхүү бүлэгт мэргэшсэн хуульч, мэргэшсэн хуульчид тооцох, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлж, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны төрөл, тэдгээрийг эрхлэх нөхцөл, журмыг тодорхойлно.

Тавдугаар бүлэгт хуульчийн сургалт, түүний төрөл, сургалтыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулж, хуулийн төслийн зургадугаар бүлэгт хуулийн зөвлөхийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулна. Энэхүү бүлэгт хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны хэлбэрийг тодорхойлж, түүний эрх зүйн байдал буюу үйл ажиллагаагаа явуулах зохион байгуулалтын хэлбэр, эрх, үүрэг, хориглох зүйлийг эрхэлж байгаа үйл ажиллагаатай нь уялдуулан тодорхойлно.

Хуулийн төслийн долдугаар бүлэгт Хуульчдын холбооны эрх зүйн байдал, түүний чиг үүргийн хороодын талаархи зохицуулалтыг тусгана. Ингэхдээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн энэ талаархи ерөнхий зарчмыг хадгалах бөгөөд чиг үүргийн хороодын бүрэлдэхүүн, ажиллах журам, дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, Их Хурал, Зөвлөлийн эрх, үүрэгтэй холбогдсон зохицуулалтыг илүү боловсронгуй болгоно. Ингэхдээ Хуульчдын холбооны үйл ажиллагаанд нийт хуульчдын оролцоог хангах, холбооны үйл ажиллагаа нь илүү нээлттэй, бүх хуульчид эрх тэгш байх зарчимд нийцүүлэх, Хуульчдын холбооны үйл ажиллагааны мэргэшсэн байдал, залгамж чанарыг хадгалах зорилго бүхий зохицуулалтыг тусгана.

Хуульчдын холбооноос зарим чиг үүргээ буюу хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх, бодлогын нөлөөлөл хийх, шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх зэрэг чиг үүргээ хэрэгжүүлэх журмыг энэхүү бүлэгт тусгана.

Хуулийн төслийн наймдугаар бүлэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнийг хүлээлгэх журмыг нарийвчлан зохицуулах бөгөөд есдүгээр бүлэгт Хуульчдын холбооны бие даасан байдлыг хангах баталгаа, Хуульчдын холбооноос хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харилцах, ажлаа тайлагнах журмыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар дараахь үр дагавар гарна гэж үзэж байна:

1.Хуулийн зохицуулалт илүү боловсронгуй болж, хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдэнэ.

2.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуульчдын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин илүү тодорхой, баталгаатай болно.

3.Гадаадын хуульч Монгол Улсад үйл ажиллагаа явуулах харилцаа илүү хяналттай болж, үйл ажиллагаа явуулах хэлбэр, төрлийг тодорхой болгоно.

4.Хуульчийн мэргэжлийн ёс зүйн маргааныг хянан шийдвэрлэх субъект, механизм тодорхой болно.

5.Хуульчдын холбооны үйл ажиллагаа боловсронгуй болж, түүнд гишүүдийн оролцох оролцоо нэмэгдэнэ.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх бөгөөд уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.